



**БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар *11/10*

Дархан баг

Г

Сумын татварын орлогын
гүйцэтгэлийн тухай

Г

Бүрэгхангай сумын Татварын улсын байцаагч Б.Должиннямын танилцуулсан “Сумын 2025 оны эхний 10 сарын татварын орлогын гүйцэтгэлийн тухай” илтгэлийг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Сумын 2025 оны татварын орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр эхний 10 сарын байдлаар 2,006.8 сая төгрөг байхаар батлагдсанаас гүйцэтгэл 1,623.1 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөө 80.9 хувь биелсэн байна.

Орлогын бүлэг	Төлөвлөгөө (мян/төг)	Гүйцэтгэл	Биелэлт хувь
Хүн амын орлого	942,519.0	1,084,826.9	115.0
Өмчийн татвар	142,693.0	96,553.8	67.7
Бусад татвар	858,043.6	395,275.4	46.1
Татварын бус орлого	63,583.0	46,400.5	89.2
Нийт дүн	2051839,3	1623056,6	80%

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Татварын орлогын гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумын Засаг дарга, Татварын улсын байцаагч нарт ДААЛГАХ нь:

1.1. Татварын орлого багатай бүлгүүдийн (ялангуяа хүү торгууль, ойгоос мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр болон бусад татварын орлого) гүйцэтгэлийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллах.

1.2. Малын тоо толгойн албан татвар болон газрын төлбөрийн бүртгэл, хураалтын ажлыг эрчимжүүлэх.

1.3. Оны эцсийн 11, 12 дугаар сарын татварын орлогын 282.2 сая төгрөгийн төлөвлөгөөг бүрэн биелүүлэх арга хэмжээг авч ажиллах.

1.4. Сумын 2026 оны төсвийн төсөлд судалгаа шинжилгээ хийж орлогыг бодитой төлөвлөх



1.5. Татварын албаны ажил үйлчилгээний талаарх мэдээллийг чанаржуулж, ойлгомжтой хэлбэрээр бэлтгэж, танилцуулахад анхаарах

2. Сумын 2025 оны татварын орлогын гүйцэтгэлийн дүнг 2025 оны 12 дугаар сарын 15-ны дотор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг Татварын улсын байцаагч (Б.Должинням)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо (С.Оргил)-д тус тус даалгасугай.

ДАРГА  Н.ЭРХЭМБАЯР

